

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ
М.ЭНХМАА МИНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2024 оны 12 дугаар сарын 18

М.Энхмаа миний бие тайлант онд 2024 оны 01 - 09 сар хүртэлх хугацаанд сан хариуцсан мэргэжилтэн, 09 сарын 06-ны өдрөөс Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогчоор тус тус томилогдон ажиллах хугацаанд дараах ажил үүргийг гүйцэтгэж ирлээ.

Нэг. Нийгмийн даатгалын сангийн санхүү бүртгэлийн хүрээнд

Монгол улсын Сангийн сайд, Хөдөлмөр Нийгэм хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246/A/245 тоот хамтарсан тушаалаар баталсан “Маягт журам батлах тухай”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн А/65 тоот тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”, Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажиллаж байна.

Анхан шатны баримтыг үндэслэн ажил олгогч, даатгуулагчдад Төрийн сан, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк, Капитрон банк, Голомт банк, Хаан банкны 12 дансаар тэтгэвэр, ҮОМШӨ-ийн сангийн тэтгэврийг шилжүүлж, дансны хуулга, үлдэгдлийг тулган нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн цахим санд бүртгэн ажиллав.

Тэтгэвэр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн тэтгэврийн өглөг, авлагыг анхан шатны баримтын дагуу шалгаж ташаарсан орлого, зарлагыг залруулж нийгмийн даатгалын сангийн өглөг авлагыг барагдуулж ажиллаж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн батлагдсан хуваарийн дагуу зардлыг зүйл зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна.

НДЕГ-тай байгуулсан арилжааны банктай хамтран ажиллах гэрээний дагуу Арилжааны банкаар гаргаж буй гүйлгээг бүртгэлтэй Email хаягаараа дамжуулан хийж байна.

Оны эхнээс төсвийн хуваарийн дагуу СБХОГ-с 235,797,9 сая төгрөгийн санхүүжилт тэтгэврийн санд, ҮОМШӨ даатгалын санд 1,9 сая нийт 234,799,8 сая төгрөгийн санхүүжилт аван сангийн зардлын гүйлгээ хийгдсэн байна.

Зардлын нэр төрлөөр зарцуулалтыг харуулбал :

			/сая төгрөгөөр/				
№	НД-ын сан		Даатгуулагчийн тоо	Сангийн зардлын төлөвлөгөө	Сангийн зардлын гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт	Хувь
1	Тэтгэвэр	Өндөр насны тэтгэвэр	19214	192075,0	93385,8	-1310.8	100.6%
2		Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	1016	6760,5	6404,7	+ 355.8	94.7%
3		Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	2444	15840,0	14976,9	+ 863.1	94.5%
4		Цэргийн алба хаагчийн тэтгэвэр	1274	21798,5	19683,2	2115.3	90.2
5	ҮОМШӨ	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	114	1275,5	1155,8	119.7	90.6
6		Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	16	0,2	0,2		100
Нийт дүн			24078	237749,7	235606,6	2143.1	99.1

Мөн тэтгэвэр авагчийн банкны үйлчилгээний хөлсийг сар бүр банкуудтай тулган баталгаажуулан тэтгэврийн сангаас 13,9 сая ҮОМШӨ-ий сангаас 0,6 сая төгрөгийг шилжүүлэн тохирох бичилтийг хийсн баталгуулсан.

ҮОМШӨ-ий сангаас Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авдаг 114 даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг жилд 2 удаа 76,7 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын санд шилжүүлэн холбогдох бичилтийг хийж гүйцэтгэлээ.

111

НДЕгазраас орж ирсэн Улсын төсвийн санхүүжилтийн 66.093,5 сая төгрөгийг Санхүү бүртгэлийн газраас өгсөн чиглэлийг баримтлан бүртгэлд тусган, хяналт тавьж ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд нийгмийн даатгалын байгууллагын системийн хэмжээнд бүх байгууллагыг баг болгон хуваарилж багийн ахлагч гишүүд хамтран уялдаа холбоотой ажиллан Ай Ти Зон ХХК-наас өгсөн заавар хийх ажлын хүрээнд харилцагчийн орлого таниулах, мөн 2023 оны жилийн эцсийн өглөг авлагын үлдэгдэлийг сан тус бүрээр нэгбүрчилэн задалж баталгаажуулан НДЕГ-т хүргүүлснээс гадна тэтгэвэр тэтгэмжийн зарлагын бүртгэл хийх мөн тэтгэвэр, тэтгэмжийн хаалт яаж хийх талаар цахим сургалтанд хамрагдан программ дээр өгсөн аврын дауу ажиллаж асуудалтай кесс болгоныг тухай бүрд нь багийн ахлагч мэргэжилтнээс тодруулж ажиллаж байна.

Нийт 6 банкнаар 4563 гүйлгээ хийгдсэнийг программ дээр оруулан өглөг хаах зарчим аргачлалаар нэг бүрчлэн хийж гүйцэтгэн оруулж ажиллаж байна.

2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд гаргаж хүргүүлсэн.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн 94047790 дугаарт ирсэн ажил олгогч, даатгуулагчийн асуусан дуудлаганд тухай бүр хариулж, иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээллийг өгсөн.

Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж үйл ажиллагааг улам сайжруулах, хадгаламжийн нэгжийн эмх цэгц, хамгаалалтад хяналт тавих ажлын хүрээнд Сангийн зарлагын гүйлгээтэй холбоотой анхан шатны баримтыг бүрдүүлж 5 банкны 10 дансны 2023 оны нийт 32 боть баримтыг хуваарийн дагуу 1 дүгээр улиралд архивын ажилтанд хүлээлгэн өгч ажиллаа. Газрын даргын баталсан хуваарийн дагуу “Угтах байцаагч”-аар 9 удаа ажиллаж, хэлтсийн дарга болсны дараа ээлжээр жижүүрийн үүрэг гүйцэтгэж хяналт тавьж иргэдийг хүлээн авч холбогдох зөвлөгөө мэдээлэл өглөө.

Гурав. Удирдлагын өгсөн үүрэг даалгаварын хүрээнд

Газар, албаны даргаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэн гарын мжээнд болон дээд газраас зохиосон аливаа ажилд идэвхитэй оролцож, ажлын цаг ашиглалтанд анхаарч, таслал, хоцролтгүй НД-ын ажилтны ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллаж байна. Үүнд:

Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зөв мэдүүлэх, төрийн албаны ёс зүйг дээдлэн хуулийн хугацаанд ХАСХОМ бөглөсөн бөгөөд <https://meduuleg.iaac.mn/> сайтад ХАСХОМ болон ХХОАТ-ын тайланг хуулийн хугацаанд илгээн баталгаажсан.

/3303/ дансны анхан шатны бүртгэлийг нягтлан шалгах, үлдэгдлийг залруулах, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах ажлын удирдамжийн дагуу 2017 оны санхүүгийн баримтанд Ц.Наранмандахын санаатай үйлдлээр гаргасан нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланд тусгагдсан бусад өглөг /3303/-р дансны бүртгэл, анх бүртгэсэн НББ-ийн бичилтийг үнэн зөв эсэхийг нягталж шалгах, ~~байгаа~~ анхан шатны

бүртгэлийг үнэн зөв бүртгэх, бусад өглөгийг залруулах чиглэлийн дагуу холбогдох гүйлгээг цахим хэлбэрт оруулан залруулгын шатанд бэлдэн ажиллаж байна.

SICOS системийн нэвтрүүлэлттэй холбоотой ажил олгогчийн бүртгэл, дан системийн нэвтрэлт, нэвтрэх эрх олгох, бүртгэлийн кодын өөрчлөлтийн талаар Орлого шимтгэлийн тасгийн сургалтанд 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр хамрагдсан.

2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Монголын бүтээмжийн төв дээр зохион байгуулагдсан ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны дотоод аудитор бэлтгэх сургалтанд хамрагдсан.

2024 оны 03 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд SICOS системд хуулга таниулах, шимтгэлийн орлого таниулах давхар болон алдаатай танигдсан ажил олгогчийн шимтгэлийн мэдээллийг дээд газрын мэргэжилтэнүүдэд тухай бүрд нь мэдээлэн ажилласан.

2024 оны 03 дугаар сарын 19 өдөр Хайлааст тасгаас зохион байгуулсан Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга, материал хүлээн авахад юун дээр анхаарах талаар мэдээ мэдээлэл солилцон хамрагдлаа.

2024 оны 03 дугаар сарын 13-04 дүгээр сарын 03-ны өдрүүдэд Сургалтын төлөвлөгөөний дагуу нийгмийн даатгалын хууль тогтоомж шинэчилсэн найруулгын талаар хуулийн хэрэгжилт болон тэтгэвэр тэтгэмж, хамралт, сайн дурын даатгалтай холбоотой нийтлэг гаргадаг алдаа дутагдлыг арилгуулах цаашид анхаарах асуулаад сургалтанд 7 хоног бүр хамрагдсан.

2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Санхүү бүртгэлийн газраас зохион байгуулсан Цэвэр агаар цасны баярт газар, хэлтсээрээ нэг өдрийг спорт, урлагийн тэмцээн зохиож хөгжилтэй сайхан өнгөрүүлээ.

2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Санхүү бүртгэлийн газраас зохион байгуулсан Хувь хүний үнэ цэнэ, хэрхэн өөрийгөө үнэлэх ажлын ачаалал даах чадварын сургалтанд хамрагдсан

2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Үйлчилгээний тасгаас Жендерийн үндэсний хорооноос Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр. Монгол цэргийн өдрийг тохиолдуулан "Харилцан хүндэтгэе" нэг сарын аяныг зохион байгуулж байгаатай холбогдуулан тус газрын хамт олон нэгдэн газрын албан ёсны цахим хуудас ((facebook) -ээр дамжуулан иргэд даатгуулагчдад уриалга хүргэж, Жендерийн тухай ойлголт сэдвийн хүрээнд сургалтанд хамрагдсан.

2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр ОБЕГ-с Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлээ. Монгол улсын засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолын хүрээнд дүүргийн засаг дарга бөгөөд онцгой комиссын даргын баталсан захирамжийн дагуу газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг дүүргийн онцгой байдлын газартай хамтран зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдлаа.

2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Архив бичиг хэрэг дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Намжилсүрэн, архивын ажилтан Б.Болорчимэг, Д.Даваажаргал нар архив бичиг хэргийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг дагуу баримыг үдэж хадгаламжийн нэгж үүсгэх, алдаа дутагдлыг арилгах сургалтыг зохион байгуулж сургалтанд хамрагдлаа.

2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Үйлчилгээний тасгаас "Хүний хөгжил-Нийгмийн баталгаа -2024" арга хэмжээ батлах тухай 32 дугаар тогтоолын хүрээнд ажилтан албан хаагчдад мэдлэг мэдээлэл олгох, амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор "Эрүүл дадлыг бүтээцгээ"сэдэвт сургалтыг сургагч багш М.Баярцэцэг удирдан явуулж эрүүл зөв хооллолтын талаар сургалтанд хамрагдсан.

2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 04 дүгээр сарын 12-ны хооронд Монголын бүтээмжийн төв нь бүтээмжийн зөвлөлийн гишүүдэд зориулан "Чанарын дугуйлан гэж юу вэ, ЧД-г хэрхэн хэрэгжүүлэх, түүний ач холбогдол, ЧД-аар дамжуулан байгууллагын бүтээмжийг хэрхэн нэмэгдүүлэх талаар ойлголт өгөх, чиглүүлэг" сургалтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтаар "ЧД-ийн гишүүдийн зохион байгуулалтыг танилцуулах, чанарын дугуйлангийн ойлголт ба зарчмын тухай, байгууллагад ЧД-г хэрэгжүүлэх менежмент арга, чанарын хяналтын үндсэн 7 арга, мөн багын ажиллагаа зохион байгуулж заавар зөвлөгөө өглөө.

2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Хүүхэд хүмүүжлийн эерэг арга, хүүхэдтэй хэрхэн хариуцах вэ сургалтыг Чингэлтэй дүүргийн хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нармандах сургалтыг удирдан явуулсан сургалтанд хамрагдсан.

Төрийн албаны зөвлөл НДЕГ зохион байгуулсан дараах цахим сургалтанд хамрагдсан.

Үүнд: Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төслийн танилцуулга, хэлэлцүүлэг

"Дижитал шилжилт: Виртуал орчинд ажиллах" "Байгууллага, хүвь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага" ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ХӨГЖИЛ, ЦАЛИН ХӨЛС, НИЙГМИЙН БАТАЛГААТАЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААГ ЗӨВХӨН НЭГ ХУУЛИАР ЗОХИЦУУЛНА "Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмын үйл ажиллагаа" "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын танилцуулга сургалт "Төрийн албан хаагч нарт зориулсан эх хэл, бичгийн мэдлэг. чадвар дадлын номын танилцуулга"

"Монгол төрийн зүтгэлтний хэв шинж (XX зууны эхэн үе)"

"Төрийн албаны унэт зүйл (эрхэмж). үе хоорондын ялгаатай байдал" "Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа"

"Байгууллага, хүвь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага" сургалтуудад цахим хэлбэрээр хамрагдсан.

ОБЕГазрын хурлын зааланд 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайд Н.Учралын "Шилэн төр, төрийн хурдан үйлчилгээ" уулзалт, зөвлөгөөнд газрын хамт олноороо хамрагдан оролцлоо.

Шуурхай чанартай төрийн үйлчилгээ аяны хүрээнд өөрөө биечлэн ирж үйлчилгээ, зөвлөгөө мэдээлэл авч чаддаггүй ХБИ-дэд зөвлөн, туслах, СДД-ын хамрах хүрээг нэмэгдүүлэх, анхан шатны үйлчилгээг хүртээмжтэй болгох үүднээс иргэдтэй утсаар холбогдон асуудлыг шийдэх ажлын хүрээнд нийт жагсаалтаар 17 иргэний мэдээллээр холбогдоход 2 иргэний утас ашиглалтанд байхгүй, 14 иргэн одоогоор асууж тодруулах зүйл байхгүй мөн төрийн үйлчилгээ цахимжиж хурдан шуурхай болж

байгаад баярлалаа гэсэн талархалын сэтгэгдэл, 1 иргэн эмнэлэг, өрх хороо, халамжийн үйлчилгээнд хангалттай хамрагдаж чаддаггүй тухай гомдолтой байгаа тухай мэдэгдэв.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Эртэч Чингэлтэйчүүд” өдөрлөгийн хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 11-ны өдөр Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хайрхан хөгжлийн төв”-д цуглан дасгал хөдөлгөөн хийж, ууланд алхалт хийн, гацуур мод тарьж суулгасан.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/241 дүгээр захирамжийн хүрээнд “Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулахад манай газрын хамт олон Улсын их дэлгүүрийн задгай талбайд иргэд, даатгуулагчдад зөвлөө, туслъя нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулан оролцсон.

2024.05.30-нд ТАЗ-с zoom-р “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг төрийн албан хаагч зөрчихөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Мэдээлэл арга зүйн газрын дарга Д.Баяндүүрэн сургалт явуулав

2024.06.06-НД ТАЗ-с zoom-р “Төрийн жинхэнэ албан хаагчийг томилох үйл ажиллагаанд гарч буй зөрчил” сэдвээр Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ явуулна. Мөн Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн сургалт явуулав

2024.06.10-ны өдрөөс эхлэн 10 удаа төрийн албаны зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу УНДЕГ-аас зохион байгуулсан монгол бичгийн zoom-ээр явуулсан сургалтанд хамрагдсан.

Монголын бүтээмжийн төвтэй хамтран Филлиппин улсад Төрийн сектор дах нээлттэй инновацийн бага хурал –д 2024 оны 08,28-29 –ний өдрүүдэд оролцсон.

2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр “Авлигын шалтгаан, хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр комиссар Р.Төрбулаг, “Авлигын гэмт хэрэг, түүний ойлголт” сэдвээр комиссар М.Жамъяачойжил нарын зохион байгуулсан сургалтад газрын нийт албан хаагч, байцаагч нар хамрагдлаа.

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ. Монгол улсын засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолын хүрээнд дүүргийн засаг дарга бөгөөд онцгой комиссын даргын баталсан захирамжийн дагуу газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг дүүргийн онцгой байдлын газрын сургалтанд хамрагдсан.

09 дүгээр сарын 03 ний өдөр Нийслэлийн прокурорын газартай тус газар нь хамтарч Авилга ашиг сонирхолын эсрэг сургалт зохион байгуулсан сургалтанд хамрагдсан.

ЧДЗДТГ-ын захирамжийн дагуу Нийслэлийн ойг утгсан бүх нийтийн цэвэрлэгээ 2024 оны 10 дугаар сарын 26 ний өдөр ЧДНДГ-ын гадна, дотор талбайг цэвэрлэсэн.

11 дүгээр сарын 01-ний өдөр тус газрын албан хаагчдын дунд гар бөмбөгийн тэмцээнд оролцож 3 дугаар байр эзэлсэн.

11 дүгээр сарын 9,10-нд штабын байр тохижуулах болон багаж хэрэгслийн бэлтгэл байдал хангах зэрэг штабын ажилтан албан хаагч нар ажил үүргийн хуваарилалт хийж, багийн ахлагчийн заавар, зөвлөмжийн дагуу бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.

Гамшгаас хамгаалах команд сургууль өглөө 05:00 цагт “Яаралтай цуглар” зарлан мэдээллийн дохиог авч, бэлтгэл, бэлэн байдлыг шалгаснаар эхэлж, дүүргийн

шуурхай штабын албан хаагч нар тухайн цагт штабын төв байранд цугларч, Хүн ам, нийгмийн хамгааллын улсын албаны заавар, зөвлөгөө, чиглэл өгсний дагуу ажил үүргийг тухай бүрд хэрэгжүүлэн заасан цаг хугацаанд тайлан мэдээг өгч, илтгэж ажиллалаа

ТАЙЛАН БИЧСЭН:

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



М.ЭНХМАА

Ажлын чиг үүргийн дагуу харилцан ажиллаж буй даатгуулагч, ажил олгогч байгууллагуудад НД-ийн хууль тогтоомжийн талаар тогтмол сурталчилгаа хийх ажлын х рээнд Ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд чиглэсэн, сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээний зардлыг холбогдох баримтыг ндэслэн Хамралт орлогын хэлтэстэй хамтран 12,4 сая т гр гийн зарлагын г йлгээг хийж ажиллаа. ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр 10 сая т гр гийг Хамралт орлогын хэлтэстэй хамтран тендер зарлан сургалт зохион байгуулж холбогдох тайланг нэгтгэн авлаа.

Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн сангаас төлөх шимтгэлийг сайн дурын даатгалын байцаагч Норжмаатай хамтран тооцоо гарган тэтгэвэр , тэтгэмжийн санд шилжүүллээ.

Мөн тэтгэврээ өөрчлүүлэх хүсэлтээ өгсөн 2620 үүнээс өндөр насны тэтгэвэр авагч 1107, цэргийн өндөр насны тэтгэвэр авагч 64, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 81, үйлдвэр ослын мэргэжлээс шалтгаалсан хөдөлмөрийн чадвар түр алдсаны 72 тэтгэвэр авагчийн ажилласан жилийн нэмэгдэл, хөдөлмөрийн чадвар түр алдсаны 1396 тэтгэврийн сунгалтыг тэтгэврийн байцаагчтай хамтран 7 хоног бүрийн мягмар гаригт арилжааны 4-н банкны 8 дансаар шилжүүлэн тэтгэврийг түргэн шуурхай олгож ирлээ.

Арилжааны банкнуудаас харилцахын чөлөөт үлдэгдэлд тооцох хүүг "Хамтран ажиллах гэрээ"-нд заасны дагуу Капитрон, Төр, Голомт, Худалдаа хөгжлийн банкнууд 2024 оны 1 дугаар сарын 1-нээс, Хаан банк 2024 оны 4 дүгээр сарын 31-нээс эхлэн хүүг тооцож олгож . төвлөрсөн сангийн дансны үлдэгдэлд тооцсон хүүгийн орлогод 3,2 сая , тэтгэврийн даатгалын санд 105,6 сая , ҮОМШӨ-ий даатгалын санд 3,6 сая, төгрөгийг хүлээн авч тооцоо нийлэн холбогдох сангийн харилцах дансуудад төвлөрүүлэн ажиллалаа.

Арилжааны банктай байгуулсан гэрээний дагуу төлбөрийн жагсаалт батлагдсан журмын дагуу бүртгэлтэй цахим хаягаар дамжуулан хийж байна.

НДЕГтай байгуулсан арилжааны банктай хамтран ажиллах гэрээний дагуу тус газрын данс байрших арилжааны 5 банкны гэрээг дүгнэн ажиллалаа.

Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн нягтлан бодох бүртгэлийг 2024 оны 01-р сараас эхлэн Core системээр бүртгэлийг хөтөлж 2024 оны 4 дүгээр улирлын тайланд бэлтгэн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн мэдээ, тайлан гаргах ажлын хүрээнд арилжааны банкнуудаас ирсэн төвлөрсөн сангийн хуулгыг үнэн зөв бүртгэж, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг дараа сарын 2-ны өдөр цаг хугацаанд нь үнэн зөв гарган цахимаар хүргэн ажиллав.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05/777 тоот албан бичгийн хэрэгжилтийг хангаж, Нийгмийн даатгалын төвлөрсөн орлого дансанд нийт 700248,29 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн бичилтэнд хяналт тавьж ажилласан.

11 дүгээр сарын 11 ний өдөр НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт судалгааны газарт Ажилгүйдлийн даатгалын сангийн зардалд төсвийн тодотгол хийлгэх тухай албан бичиг хүргүүлсэн болно.

Цаашид батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллаж тайлан мэдээг үнэн зөв цаг хугацаанд нь гарган тэтгэвэр олголтонд илэрсэн зөрчлийг тухай бүр залруулан ямар нэг алдаа дутагдал гаргахгүй төлөвлөсөн ажлаа нэг бүрчлэн биелүүлэн даатгуулагч болон ажил олгогч нараас гарсан санал хүсэлтийг тухай бүр шийдэж нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан ажиллаа.

Ухаалаг ажлын байр төслийг хэрэгжүүлэх явцад ажил үйлчилгээнд гарч байгаа алдаа зөрчил иргэд даатгуулагчдаас ирж байгаа өргөдөл гомдлыг чирэгдэлгүй шуурхай шийдвэрлэх төрийн үйлчилгээний төгөлдөршлийг бий болгох зорилгоор Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт"-ын ажлын өрөөний тавилгын стандартын дагуу бичгийн ширээний шүүгээний эхний нүдэнд бичгийн хэрэгсэл, тооны машин, хоёр дахь нүдэнд хууль тогтоомж, гарын авлага маягт, холбогдох бичиг баримт, гурав дахь нүдэнд хувийн эд зүйлсээ байршуулж, түүнчлэн ажилтан бүр нэр, албан тушаал зэрэг хаяг бүхий мэдээлэлийн хаяг байрлуулсан. Албаны бүх баримтыг "D" диск дотор "ajliin file" гэсэн хавтас үүсгэн он оноор нь, хувийн файлуудыг "C" диск дээр "Huviiin file" гэсэн хавтас дотор хадгалж байна. Компьютерын дэлгэц дээр 10-аас илүүгүй хавтас байршуулж мэдээллийн нууц аюулгүй байдлыг ханган ажилласан. Чанарын удирдлагын тогтолцоо ISO стандарт хэрэгжүүлэх ажлын хүрээнд 5C зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Газрын даргын тушаалаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх болон хяналт тавих ажилтнуудын ажил үүргийн хуваарийг шинэчлэн мэдээ, мэдээллийг байршуулах, олон нийтэд хүргэх, сайтанд байршуулсан мэдээллийг хянах, ажлын дүн мэдээг гаргах зэргээр шинэчлэн баталсан.

2024 оны эхнээс шилэн дансны сайт шинэчлэгдсэн бөгөөд хуучин программаас мэдээ, мэдээллүүдийг шинэчилж оруулсан.

Газрын мэдээллийн самбарт сар бүрийн санхүүгийн мэдээг тогтмол шинэчлэн байршуулж хэвшүүлсэн. Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын төсвийн мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй, хуулийн хугацаанд нийтдээ 32 нэр төрлийн 267 мэдээ мэдээллийг сар бүрийн 8-ны дотор шилэн дансны www.shilendans.gov.mn сайтад байршуулан ажиллаж байна.

Шилэн дансны мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй байршуулсныг хяналт тавих, дүн шинжилгээ хийх ажлыг Хяналт, захиргаа удирдлагын хэлтсээс тухай бүр хяналт тавьж ажиллаагүйн улмаас НДЕГ-ын Дотоод аудит, мониторингийн газраас орсон шалгалтаар газрын шилэн дансны мэдээлэл 2,1 тэрбум төгрөгийн мэдээлэл дутуу оруулсан, сан 230,0 сая төгрөгийн мэдээлэл дутуу оруулсан зөрчил илрэн зөвлөмж авсан. Цаашид давтан зөрчил гаргахгүй хяналт сайтай ажиллах шаардлагатай байна.

Дөрөв. Сангийн бусад өглөг, авлагын талаар /1218, 3303 тоот данс/

Улсын байцаагчийн акт тавигдаагүй НББ-ийн бүртгэлийн бичилтээр даатгуулагч нэр дээр шууд авлага үүсгэж, тэтгэврийн улсын байцаагчийн актаар